МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА






# ГоАМЛ Вэб порталд бүртгүүлэх гарын авлага

Хувилбар 1.2

2023 оны 03 дугаар сар

## ГоАМЛ вэб порталын нэвтрэх хуудас

ГоАМЛ порталд дараах холбоосоор нэвтэрнэ:

https://goaml.mongolbank.mn/

- Нэвтрэх: Системд нэвтрэх
- Бүртгүүлэх: Хэрэглэгчээр бүртгүүлэх хуудас
- Гарын авлага: ГоАМЛ-тэй холбоотой баримт бичиг, гарын авлагын холбоос
- Холбоо барих: СМА-тай холбоо барих цахим шуудангийн холбоос




## *Бүртгэл*

1. **Бүртгүүлэх цонх дээр дарна.**
2. **Мэдээлэх үүрэгтэй этгээд цонх дээр дарна.**




- ❑ Хэрэв мэдээлэх үүрэгтэй этгээд нь анх удаа бүртгүүлж байгаа бол "Мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийг сонгоно.
- ❑ Өмнө бүртгүүлсэн мэдээлэх үүрэгтэй этгээдэд шинээр хэрэглэгч нэмэх бол "Хэрэглэгч бүртгүүлэх" (Хэрэглэгч (МҮЭ)-ийг сонгоно.

# 3. “Мэдээлэх үүрэгтэй этгээд” цонхны холбогдох мэдээллийг бөглөнө.

Нэрийг заавал **кирилл үсгээр**, товчлолгүй бичих бөгөөд нэрний хойно банк, ББСБ, ХЗХ, ҮХХЗ, МЗҮАЭЭ, нотариатч гэх мэт МҮЭ-ийн төрлийн нэрийг оруулж бичнэ.

**Иргэн:** Өөрийн нэрийн хойно МЗҮАЭЭ, хуульч, нотариатч гэх МҮЭ-ийн төрлийн нэрийг хамт бичнэ.

Жишээ нь: Сайханбаяр.Г МЗҮАЭЭ

**Хуулийн этгээд:** Улсын бүртгэлийн олоосон нэрийг бичнэ. Аж ахуйн нэгжийн төрөл болох ХХК болон ХК-г бичих шаардлагагүй. Хуулийн этгээдийн төрлийг тусад нь оруулна.

Жишээ нь: Bayan BBSB эсвэл Баян ХХК биш харин Баян ББСБ.




**Иргэн:** Тусгай үнэмлэхний дугаар эсхүл регистрийн дугаарыг бичнэ.

**Хуулийн этгээд:** Тухайн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн регистрийн дугаарыг бичнэ.

**Иргэн:** “Бусад” гэсэн сонголтыг сонгоно.

**Хуулийн этгээд:** Сонголтоос хамгийн тохиромжтой ангиллыг сонгоно. Жишээ нь: Хязгаарлагдмал хариуцлагатай компани

МҮЭ-ийн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн чиглэлийг сонгоно.

Жишээ нь: Банк, ББСБ, нотариатч гэх зэрэг өөрийн байгууллагын тохирохоо сонгоно.

ГоАМЛ-тэй холбогдоход ашиглах и-мэйл хаяг. Мөн бүртгэл, тайлан, цахим зурвастай холбоотой бүх харилцаа, мэдэгдлийг энэ хаягаар илгээнэ.

Заавал! талбаруудыг зайлшгүй бөглөх ба хоосон үед улаан өнгөтэй болж харагдана.
Бусад талбарт холбогдох мэдээллийг оруулах боломжтой.

# 3. “Мэдээлэх үүрэгтэй этгээд” цонхны холбогдох мэдээллийг бөглөнө.

***Утас болон хаягийн мэдээллийн дэлгэрэнгүй маягт***




| Талбарын цонхны нэр | Утас жишээ бүхий дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|
| ***Холбооны төрөл** | Сонголтоос холбоо барих төрлийг сонгоно. Жишээ нь: Бизнес, албан |
| ***Утасны төрөл** | Сонголтоос тохирох утасны төрлийг сонгоно. Жишээ нь: Оффисын утас, Гар утас |
| ***Дугаар** | Улсын кодгүй дугаар. Зөвхөн тоо агуулсан байх ёстой. Жишээ нь: 77000000 |

| Талбарын цонхны нэр | Хаяг жишээ бүхий дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|
| ***Төрөл** | Сонголтоос хаягийн төрлийг сонгоно. Жишээ нь: Бизнес |
| ***Хаяг** | Дүүрэг, хороо, гудамжны нэр, байшингийн дугаар, тоотыг оруулна. Жишээ нь: СБД, 1-р хороо, Сэнтрал тауэр 701 тоот |
| ***Хот/Аймаг** | Байгууллагын байршлыг бичнэ.<br>Жишээ нь:<br>• Улаанбаатар хот<br>• Төв аймаг |
| ***Улс** | Оршин суугаа улсын нэр Жишээ нь: Монгол Улс |

Утасны дугаар, хаягийн мэдээллийг бөглөхийн тулд + товшино. Утасны дугаар эсвэл хаягийг нэмсний дараа + тэмдэг нь идэвхтэй хэвээр байх тул хэрэглэгч нэмэлт утасны дугаар эсвэл хаяг оруулах боломжтой.
Шаардлагагүй гэж үзвэл 🗑 тэмдэг дээр дарж устгана.

# 4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн бүртгэлийн явцад эхний хүнийг бүртгэх /Админ/




| Талбарын цонхны нэр | Жишээ бүхий дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|
| *Хэрэглэгчийн нэр | Хэрэглэгчийн нэрийг зөвхөн **латин үсгээр үүсгэнэ**. ГоАМЛ порталын цаад өгөгдөл нь нэвтрэх нэрийг кирилл үсгээр оруулахад алдаа заадаг болно. Хэрэглэгч ГоАМЛ-д нэвтрэх бүрт энэ мэдээллийг оруулах шаардлагатай. Хэрэглэгчийн нэр нь бүртгэгдсэн бүх ГоАМЛ хэрэглэгчдийн дунд өвөрмөц байх ёстой бөгөөд урьд нь бүртгэгдсэн хэрэглэгчийн нэртэй ижил байж болохгүй гэдгийг анхаарна уу.<br><br>Жич: Олон хэрэглэгч бүртгүүлдэг санхүүгийн байгууллагынхан товчилсон нэрээ эсвэл байгууллагынхаа төрлийг хэрэглэгчийн нэрийн өмнө хэрэглэнэ үү.<br><br>Жишээ нь: lmb.Khuslen, nbfi.Murun гэх мэт.<br><br>Доорх хүснэгтэд нэвтрэх нэрийн өмнөх угтварыг харуулав. |

| Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагааны чиглэл | Нэвтрэх нэрийн өмнөх угтвар |
|---|---|
| Банк бус санхүүгийн байгууллага | nbfi. |
| Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч | ins. |
| Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага | sec. |
| Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани | inv. |
| Хадгаламж, зээлийн хоршоо | cre. |
| Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага | rl. |
| Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч | pmd. |
| Нотариатч | not. |
| Хуульч | law. |
| Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч | acc. |
| Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд | lmb. |

# 4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн бүртгэлийн явцад эхний хүнийг бүртгэх /Админ/ үргэлжлэл




| Талбарын цонхны нэр | Жишээ бүхий дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|
| *Эцэг/эхийн нэр | Хэрэглэгч өөрийн овгийг бүрэн оруулна. Жишээ нь: Тулга |
| *Өөрийн нэр | Хэрэглэгч өөрийн нэрийг бүрэн оруулна. Жишээ нь: Хүслэн |
| *Нууц үг | Нууц үгийн урт хамгийн багадаа 8 тэмдэгт, хамгийн ихдээ 20 тэмдэгтэй байж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:<br>- доод тал нь нэг жижиг үсэг [a-z]<br>- доод тал нь нэг том үсэг [A-Z]<br>- доод тал нь нэг цифр [0-9]<br>- доод тал нь нэг тусгай тэмдэгт оруулна: -+!#%&?*,.@£$\{\}=_§<br>Нууц үгээ нууцалж 1 жил тутамд сольж байх шаардлагатай.<br>Жишээ нь: Bnvjlde41@15 |
| Хүйс | Хүйсийн мэдээллийг сонголтоос сонгоно. Жишээ нь: Эм |
| Төрсөн огноо | Төрсөн огноог бичнэ. Жишээ нь: 1999.01.30 |
| Регистрийн дугаар | Улсын бүртгэлд бүртгэлтэй өөрийн регистрийн дугаарыг бичнэ. Жишээ нь: УӨ91123013 |
| Харьяалал | Иргэний харьяаллын мэдээллийг сонголтоос сонгоно. Жишээ нь: Монгол Улс |
| *Албан тушаал | Одоогийн албан тушаалыг бүрэн оруулна. Жишээ нь: Гүйцэтгэх захирал |
| И-мэйл | Ажлын албан цахим шуудангийн хаяг оруулах шаардлагатай. Мөн бүртгэл, тайлан, цахим зурвастай холбоотой бүх харилцаа, мэдэгдлийг энэ хаягаар илгээнэ.<br>Жич: Энэхүү талбарт өмнөх хуудаст бичсэн мэйл хаягийг бичих боломжтой. |

# 5. “Хянаад илгээх” товчийг дарах




Системд бүртгүүлэхэд хавсралт материал шаардахгүй.




Бүх талбаруудыг бөглөж дууссаны дараа бүртгэлийн мэдээллийг дахин шалгаж, дэлгэц дээр харуулсан аюулгүй байдлын кодыг (captcha) оруулаад **“Хянаад илгээх" товчийг сонгоно.**

Тухайн бүртгэлийн хэсэг алдаатай эсвэл дутуу бол улаан баганаар харагдах бөгөөд бүртгэлийн товч идэвхжих боломжгүй. Бүх хэсгүүд ногоон баганаар харагдах тохиолдолд бүртгэлийг илгээх боломжтой.







“Бүртгэл зөвшөөрсөн тухай” мэйл таны бүртгүүлсэн цахим хаягт ирсний дараа таны системд нэвтрэх эрх үүснэ.

Системд амжилттай нэвтэрсний дараа ГоАМЛ нүүр хуудас нээгдэнэ.

Энэхүү гарын авлагыг Мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан хүлээж авах ГоАМЛ вэб портал https://goaml.mongolbank.mn-ын хэрэглэгчдэд зориулав.

Энэ гарын авлагад хэрэглэгчээр бүртгүүлэхтэй холбоотой мэдээллийг тусгасан болно.

Санхүүгийн мэдээллийн алба
Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс
Утас: 976-11-326161, 976-11-321919
E-mail: fiu@mongolbank.mn
Веб: https://fiu.mongolbank.mn/